



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 02 дугаар сарын 08 өдөр

Дугаар 15

Хэрлэн сум

XV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 15 дугаар хуралдаан 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 16:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 83,3 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Сар шинийн баярын өдрүүдэд зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох эсэх талаар санал хэлэлцэх,

*Цагдаагийн газар*

2.Аймгийн сайн малчдад шагнал гардуулах талаар санал танилцуулах,

*Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат*

3. Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичгийг танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

4.Хилийн Эрэнцав боомтод ажилласан тухай танилцуулах,

*АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга,


Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын орлогч, Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга нарт:

1.1.Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар Цагдаагийн газрын саналын дагуу аймгийн Засаг даргын захирамж гаргаж олон нийтэд мэдээлэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.2.Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байх талаар аймаг, сумын Морин спорт, уяачдын холбоонд албан бичгээр чиглэл хүргүүлэхийг,

 /М.Бадамсүрэн  
/Д.Баттулга

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын орлогч, Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга-д:

1.3.Хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглох тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл боловсруулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

1.4.Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сар шинийн баярын өдрүүд буюу 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 02 дугаар сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд сум хооронд зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох тухай аймгийн Онцгой комиссын тогтоол боловсруулж батлуулахыг,

1.5.Шинийн 1,2,3 буюу 2021 оны 02 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд сум доторх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох тухай аймгийн Онцгой комиссын тогтоол боловсруулж батлуулахыг,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.6.Улаанбаатар хотоос ирсэн гэрийн ажиглалтад байгаа иргэдэд өндөр хяналт тавьж ажиллахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:


1.7.Сар шинийн баярыг тэмдэглэхгүй байх нь зүйтэй гэсэн Монгол Улсын Засгийн газрын тогтоол, аймгийн Онцгой комиссын тогтоолуудыг хавсаргаж агентлаг, төрийн болон төрийн өмчит байгууллага, сумын Засаг дарга нарт албан бичгээр чиглэл хүргүүлэхийг,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн А.Нансалмаа нарт:

1.8.Сар шинийн баярыг тэмдэглэхгүй байх нь зүйтэй гэсэн Монгол Улсын Засгийн газрын тогтоол, аймгийн Онцгой комиссын тогтоолуудыг хэрэгжүүлэх ажлыг сумын Онцгой комисс, төсөвт байгууллагууд хамтарч зохион байгуулах талаар зөвлөмж хүргүүлэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

1.9.Мэргэжлийн байгууллагууд хамтран 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах

 /М.Бадамсүрэн  
/Д.Баттулга

зорилгоор улс, аймгийн Онцгой комиссоос гарсан шийдвэрийн талаар танилцуулах ажлыг сумдын Онцгой комиссын бүрэлдэхүүнд цахимаар зохион байгуулахыг,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

1.10.Төрийн байгууллага, орон нутгийн өмчит байгууллагын удирдлагуудад коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр улс, аймгийн Онцгой комиссоос гарсан шийдвэрийн талаар цахимаар танилцуулах хуваарийг гаргаж батлуулахыг,

АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх-д:

1.11.Хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгж байгууллагын удирдлагуудад коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр улс, аймгийн Онцгой комиссоос гарсан шийдвэрийн талаар цахимаар танилцуулах хуваарийг гаргаж батлуулахыг,

Хоёр.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат-д:

2.1.“Аймгийн аварга малчин өрх”, “Аймгийн аварга тариаланч хамт олон”, “Аймгийн аварга тариаланч” нарын шагналыг өрх бүрт очиж гардуулах ажлыг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулахыг,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын лабораторит шинжилгээнд явуулсан халдваргүйжүүлэлтийн бодист шинжилгээ хийлгэхэд гарсан 83,000 төгрөгийн зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт олгохыг,

3.2.Сар шинийн өдрүүдэд сум хооронд зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан Хэрлэн суманд 12 шалган нэвтрүүлэх цэгийн ажиллах албан хаагч нарт шаардлагатай нэг удаагийн амны хаалт 2000 ширхэг, гар ариутгагч /0,33л/ 11 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас аймгийн Цагдаагийн газарт олгохыг,

3.3.Хөлөнбуйр сумын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Шинжилгээ авах байранд үйлчлэгч ажиллуулах 1 дүгээр улирлын зардал 1,260,000 төгрөгийг шийдвэрлүүлэх тухай” хүсэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

3.4.Эрүүл мэндийн газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Нэг удаагийн хурдавчилсан оношлуур 525 ширхэгийг худалдан авах зардал 9,870,000 төгрөгийг шийдвэрлүүлэх тухай” хүсэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА

